

# ХҮҮХДЭД АЮУЛГҮЙ ОЛОН НИЙТИЙН ЁС ЗҮЙН ДҮРЭМ



Энэхүү Ёс зүйн дүрэм нь Parramatta хотын зөвлөлийн сургуулийн өмнөх боловсролын төв, номын сан, олон нийтийн төв, байгууламж, амралт чөлөөт цагийн төв, түрээсийн газар зэрэг Зөвлөлийн байгууламж, үйлчилгээг ашиглаж буй хэн бүхэнд хамаарна.

Зөвлөлийн Хүүхдэд аюулгүй дүрэм журмын хүрээнд хүүхэд гэж 18 нас хүрээгүй аливаа хүнийг хэлнэ.

## Зөвлөлийн байгууламж, үйлчилгээг ашиглаж буй хэн бүхэн дараах зүйлийг хийх **ёстой**:

- ✓ Хүүхэд залуучуудад хүндэтгэлтэй хандаж, тэдний санаа, бодлыг үнэлэх.
- ✓ Хүүхэд залуучуудтай харилцахдаа эерэг үлгэр дууриал болох.
- ✓ Хүүхэд залуучуудын биед шаардлагагүй хүрэхээс зайлсхийх.
- ✓ Хэрэв хүүхэд хүчирхийлэлд өртөх эрсдэлтэй бол цагдаад хандах - утасны дугаар 000.
- ✓ Хүүхэд эсвэл залуу хүнд ноцтой хохирол учрах эрсдэлтэй байна гэсэн үндэслэл бүхий сэжиг байвал Зөвлөлийн ажилтан эсвэл Хүүхэд хамгааллын тусламжийн 132 111 дугаарын утсаар мэдэгдэх.

## Зөвлөлийн байгууламж, үйлчилгээг ашиглаж буй хэн бүхэн дараах зүйлийг хийж **болохгүй**:

- ✗ Хүүхэд залуучуудыг ичээх, доромжлох, дарамтлах, үл ойшоох, гутаах.
- ✗ Аливаа хүүхдийг хууль бусаар ялгаварлан гадуурхах.
- ✗ Хүүхэд эсвэл залуу хүнд бие, сэтгэл санааны хувьд гэм хор учруулж болзошгүй үйлдэл хийх.
- ✗ Хүүхдийн өмнө хувцсаа тайлах эсвэл ямар нэгэн байдлаар бэлгэ эрхтэнээ ил гаргах.
- ✗ Хүүхдэд сээтэгнэх, өдөх, бэлгийн сэдэл өгөх.
- ✗ Бэлгийн шинж чанартай хошигнол эсвэл сэдэл өгөх.
- ✗ Тодорхой хүүхэд эсвэл залуу хүнтэй хэрэгцээнд нь зориулсан “онцгой” харилцааг хөгжүүлэх.
- ✗ Таны асран хамгаалж, хариуцаж буй хүүхдүүдээс гадуурх хүүхэд, залуучуудтай холбоо тогтоох, тэр дундаа онлайн харилцаа холбоо тогтоох.
- ✗ Хүүхэд болон түүний эцэг эх, асран хамгаалагчийн зөвшөөрөлгүйгээр хүүхэд, залуучуудын зураг авах, видео бичлэг хийх.
- ✗ Хүүхдүүдийн дэргэд насанд хүрсэн хүмүүсийн шинж чанартай нээлттэй хэлэлцүүлэгт оролцох.
- ✗ Хүүхдүүдийн дэргэд зохисгүй үг хэллэг ашиглах.
- ✗ Хүүхдийг хүслийнх нь эсрэг ямар нэгэн зүйл хийхийг албадах.
- ✗ Таны асран хамгаалах, хариуцах үүргээс гадуурх хүүхэдтэй шаардлагагүй холбоо барих.
- ✗ Хувцас солих өрөө, ариун цэврийн өрөөнд гар утсаараа зураг авах, видео бичлэг хийх.
- ✗ Зөвшөөрөл авсан зүйлээс гадуур хүүхэд, залуу хүний зураг, мэдээллийг бүртгэх, хадгалах, түгээх.
- ✗ Ёс зүйн зөрчлийн талаар мэдээлэхийг зогсоох эсвэл хориглох.

